

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/65/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас:51-261665 Цахим хаяг:naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: П. Чанцалдулам  
Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn  
аудитор: Г.Тэлмүүн  
Утас: 51-261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн : Төгсгүүд консалтинг аудит ХХК  
Захирал: Р.Даваа  
Утас: 75070778 Цахим хаяг: info@tgcaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	13
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд..	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	16
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	21
4.1 Ерөнхий зүйл .....	21
4.2 Материаллаг байдал .....	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	22
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	23
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	25
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл .....	25
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	25

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд найрамдах Хятад ард улс
НББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОХУ	Оросын холбооны улс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УЦС	Усан цахилгаан станц
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШУ	Шинжлэх ухаан
ШУА	Шинжлэх ухааны академи



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

ГАЗАРЗҮЙ, ГЕОЭКОЛОГИЙН  
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ А.ДАШЦЭРЭН  
ТАНАА

2026.03.05 № 06/518  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Эгийн голын усан цахилгаан станц төслийн 151,108.0, мянган төгрөг, Шинжлэх ухаан технологийн сангийн төслийн 124,262.6 мянган төгрөг болон бусад төсөл хөтөлбөрүүдийн 377,179.8 мянган төгрөгийн оны эцсээр төлөгдсөн гэрээт ажлын төлбөрийг төрийн санд буцаан төвлөрүүлж, 652,550.4 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын их хурлын 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл"-д "Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас

бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй, байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог 9.0 хувиар бууруулах арга хэмжээг авч ажиллаагүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	352,760,095.99	698,433,497.39
33	АВЛАГА	315,154,895.99	652,550,392.39
33300	Татаас, санхүүжилтийн авлага	315,154,895.99	652,550,392.39
35	БАРАА МАТЕРИАЛ	37,605,200.00	45,883,105.00
35100	Түүхий эд материал	28,800,000.00	35,728,505.00
35110	Тусгай зориулалттай материал	28,800,000.00	35,728,505.00
35400	Хангамжийн материал	8,805,200.00	10,154,600.00
35410	Бичиг хэргийн материал	3,304,250.00	6,004,750.00
35420	Аж ахуйн материал	1,740,950.00	3,449,850.00
35440	Түлш, шатах тослох материал	3,760,000.00	700,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,796,756,106.94	3,001,300,491.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,796,756,106.94	3,001,300,491.18
39200	Биет хөрөнгө	2,072,678,869.45	2,288,387,916.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,853,642,808.30	1,853,642,808.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(435,211,012.54)	(498,726,605.86)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	109,940,000.00	140,540,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(63,774,250.13)	(70,943,250.17)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	901,662,907.89	1,230,474,080.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	(447,940,549.37)	(517,141,322.22)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	183,844,854.37	150,419,803.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	(89,285,127.52)	(66,961,586.56)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,185,880.00	3,777,490.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,298,574.12)	(1,605,433.08)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	3,600,000.00	3,600,000.00
39217	Ном	53,311,932.57	61,311,932.57
39300	Биет бус хөрөнгө	724,077,237.49	712,912,574.89
39301	Програм хангамж	10,469,984.00	11,219,984.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,510,826.51)	(7,357,489.11)
39303	Бусад биет бус хөрөнгө	720,796,080.00	720,796,080.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,678,000.00)	(11,746,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>3,149,516,202.93</b>	<b>3,699,733,988.57</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,000,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,000,000.00
41300	Өглөг	-	2,000,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	2,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,149,516,202.93	3,697,733,988.57
51	Засгийн газрын хувь оролцоо	3,149,516,202.93	3,697,733,988.57

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51100	Засгийн газрын оруулсан капитал	1,741,521,060.73	1,741,521,060.73
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	1,741,521,060.73	1,741,521,060.73
51200	Хуримтлагдсан үр дүн	(405,919,825.68)	142,297,959.96
51210	Өмнөх үеийн үр дүн	(48,676,513.96)	(405,919,825.68)
51220	Тайлант үеийн үр дүн	(357,243,311.72)	548,217,785.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,813,914,967.88	1,813,914,967.88
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>3,149,516,202.93</b>	<b>3,699,733,988.57</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>5,688,360,080.65</b>	<b>7,661,035,290.79</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	164,700,000.00	7,661,035,290.79
120	Нийтлэг татварын бус орлого	164,700,000.00	444,056,802.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	164,700,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	164,700,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	444,056,802.76
122	Тусламжийн орлого	-	7,216,978,488.03
1221	Хандив тусламж /дотоод/	-	7,216,978,488.03
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	5,397,771,300.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	5,397,771,300.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,819,207,188.03
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	363,257,105.03
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,046,911,100.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	409,038,983.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,523,660,080.65	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,433,740,800.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,433,740,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,089,919,280.65	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	257,720,963.65	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	564,977,400.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	267,220,917.00	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>6,045,603,392.37</b>	<b>7,112,817,505.15</b>

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,045,603,392.37	7,112,817,505.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,976,624,838.62	6,356,494,981.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,907,777,695.09	4,365,161,535.28
210101	Үндсэн цалин	2,764,796,405.06	2,623,301,461.35
210102	Нэмэгдэл	551,681,100.79	565,444,229.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	242,732,663.00	478,416,000.00
210104	Урамшуулал	7,830,720.00	190,765,940.00
210105	Гэрээт ажлын хөлс	340,736,806.24	507,233,904.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	486,951,252.20	556,181,523.81
210201	Тэтгэврийн даатгалын зардал	347,541,029.88	404,032,738.68
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	37,293,384.54	40,474,365.39
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	18,028,849.31	19,503,901.05
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	16,767,573.61	18,392,150.13
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	67,320,414.86	73,778,368.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,282,626.84	80,602,655.76
210301	Гэрэл, цахилгаан	27,901,394.96	33,952,736.29
210302	Түлш, халаалт	38,558,117.54	37,595,401.97
210303	Цэвэр, бохир ус	10,823,114.34	9,054,517.50
2104	Хангамж, бараа материалын зардал	261,685,398.91	137,777,031.00
210401	Бичиг хэрэг	34,709,820.00	24,409,590.00
210402	Тээвэр, шатахуун	111,517,622.00	85,538,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,145,006.91	3,073,491.00
210404	Ном, хэвлэл	34,718,861.00	1,100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	840,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	76,994,089.00	22,815,400.00
2105	Нормативт зардал	54,464,203.00	16,761,664.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	54,464,203.00	16,761,664.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	97,990,300.00	2,550,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	330,000.00	2,550,000.00
210604	Урсгал засвар	97,660,300.00	-
2107	Томилолт, зочны зардал	365,103,623.00	408,769,768.50
210701	Гадаад албан томилолт	28,634,223.00	104,777,596.50
210702	Дотоод албан томилолт	336,469,400.00	303,992,172.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	283,665,182.69	319,978,376.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	269,849,982.69	307,053,042.42
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,158,100.00	381,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	412,500.00	1,000,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	-
210807	Газрын төлбөр	6,178,600.00	6,543,734.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	441,704,556.89	468,712,426.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	118,599,153.00	115,466,085.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	64,451,175.00	64,986,433.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	258,654,228.89	288,259,908.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,978,553.75	756,322,523.86
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	578,390,463.53

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	578,390,463.53
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	578,390,463.53
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	578,390,463.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,983,018.00	177,932,060.33
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	21,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,791,418.00	156,932,060.33
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,191,600.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,995,535.75	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,162,858.75	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	832,677.00	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(357,243,311.72)</b>	<b>548,217,785.64</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>(357,243,311.72)</b>	<b>548,217,785.64</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>6,183,040,774.47</b>	<b>7,532,133,384.02</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	7,532,133,384.02
122	Тусламжийн орлого	-	7,532,133,384.02
1221	Хандив тусламж /дотоод/	-	7,532,133,384.02
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	5,397,771,300.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	5,397,771,300.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,134,362,084.02
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	584,040,413.91
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,141,282,687.11
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	409,038,983.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,183,040,774.47	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,433,740,800.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,433,740,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,749,299,974.47	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	579,133,051.47	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	902,946,006.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	267,220,917.00	-

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,068,870,639.47	7,483,385,894.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,068,870,639.47	7,483,385,894.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,684,737,189.73	6,074,512,977.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,908,603,284.28	4,363,161,535.28
210101	Үндсэн цалин	2,777,251,725.34	2,622,685,256.81
210102	Нэмэгдэл	538,419,121.37	565,016,948.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	242,438,932.55	477,539,678.49
210104	Урамшуулал	7,830,720.00	190,685,746.75
210105	Гэрээт ажлын хөлс	342,662,785.02	507,233,904.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	486,125,663.01	556,181,523.81
210201	Тэтгэврийн даатгалын зардал	350,930,263.01	404,032,738.68
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	33,798,900.00	40,474,365.39
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	16,899,400.00	19,503,901.05
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	16,899,400.00	18,392,150.13
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	67,597,700.00	73,778,368.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,282,626.84	80,602,655.76
210301	Гэрэл, цахилгаан	27,901,394.96	33,952,736.29
210302	Түлш, халаалт	38,558,117.54	37,595,401.97
210303	Цэвэр, бохир ус	10,823,114.34	9,054,517.50
2104	Хангамж, бараа материалын зардал	140,608,429.91	92,829,001.00
210401	Бичиг хэрэг	32,329,170.00	15,937,410.00
210402	Тээвэр, шатахуун	9,723,192.00	3,970,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,145,006.91	3,073,491.00
210404	Ном, хэвлэл	87,684,861.00	61,210,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	840,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,126,200.00	7,798,100.00
2105	Нормативт зардал	68,392,923.00	59,495,554.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	68,392,923.00	58,120,554.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,375,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	165,544,817.00	45,940,880.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	33,147,800.00	20,015,680.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	19,368,134.00	4,601,500.00
210604	Урсгал засвар	113,028,883.00	21,323,700.00
2107	Томилолт, зочны зардал	467,488,053.00	488,248,318.50
210701	Гадаад албан томилолт	28,634,223.00	104,777,596.50
210702	Дотоод албан томилолт	438,853,830.00	383,470,722.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	302,722,217.69	321,578,376.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	288,907,017.69	308,653,042.42
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,158,100.00	381,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	412,500.00	1,000,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	-
210807	Газрын төлбөр	6,178,600.00	6,543,734.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,969,175.00	66,475,133.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	67,969,175.00	66,475,133.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	384,133,449.74	1,408,872,916.25
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,230,940,855.92

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	1,230,940,855.92
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	1,230,940,855.92
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	578,390,463.53
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	652,550,392.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,983,018.00	177,932,060.33
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	21,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,791,418.00	156,932,060.33
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,191,600.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	323,150,431.74	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,162,858.75	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	315,987,572.99	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>114,170,135.00</b>	<b>48,747,490.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>114,170,135.00</b>	<b>48,747,490.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>114,170,135.00</b>	<b>48,747,490.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	114,170,135.00	48,747,490.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	114,170,135.00	48,747,490.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(114,170,135.00)</b>	<b>(48,747,490.00)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-</b>	<b>-</b>
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,741,521,060.73	1,813,914,967.88	(48,676,513.96)	3,506,759,514.65
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,741,521,060.73	1,813,914,967.88	(48,676,513.96)	3,506,759,514.65
4	Тайлант үеийн үр дүн	-	-	(357,243,311.72)	(357,243,311.72)
5	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,741,521,060.73	1,813,914,967.88	(405,919,825.68)	3,149,516,202.93
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,741,521,060.73	1,813,914,967.88	(405,919,825.68)	3,149,516,202.93
7	Тайлант үеийн үр дүн	-	-	548,217,785.64	548,217,785.64

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

8	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,741,521,060.73	1,813,914,967.88	142,297,959.96	3,697,733,988.57
---	---------------------------------------	------------------	------------------	----------------	------------------

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>5,444,778,400.00</b>	<b>4,819,380,836.47</b>	<b>625,397,563.53</b>	<b>88.51</b>
12	Татварын бус орлого	5,444,778,400.00	4,819,380,836.47	625,397,563.53	88.51
122	Тусламжийн орлого	5,444,778,400.00	4,819,380,836.47	625,397,563.53	88.51
122005	Төсвөөс санхүүжих	5,444,778,400.00	4,819,380,836.47	625,397,563.53	88.51
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,444,778,400.00</b>	<b>4,819,380,836.47</b>	<b>625,397,563.53</b>	<b>88.51</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,444,778,400.00	4,819,380,836.47	625,397,563.53	88.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,266,768,200.00	4,641,448,776.14	625,319,423.86	88.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,366,515,100.00	3,855,927,631.03	510,587,468.97	88.31
210101	Үндсэн цалин	2,136,618,800.00	2,622,685,256.81	(486,066,456.81)	122.75
210102	Нэмэгдэл	1,316,979,400.00	565,016,948.98	751,962,451.02	42.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	646,418,200.00	477,539,678.49	168,878,521.51	73.87
210104	Урамшуулал	266,498,700.00	190,685,746.75	75,812,953.25	71.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	555,616,100.00	486,756,992.93	68,859,107.07	87.61
210201	Тэтгэврийн даатгал	359,969,200.00	334,608,207.80	25,360,992.20	92.95
210202	Тэтгэмжийн даатгал	48,995,500.00	40,474,365.39	8,521,134.61	82.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,472,300.00	19,503,901.05	4,968,398.95	79.70
210204	Ажилгүйдлийн даатгал	24,433,900.00	18,392,150.13	6,041,749.87	75.27
210205	Эрүүл мэндийн даатгал	97,745,200.00	73,778,368.56	23,966,831.44	75.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,045,000.00	80,602,655.76	11,442,344.24	87.57
210301	Гэрэл, цахилгаан	41,875,400.00	33,952,736.29	7,922,663.71	81.08
210302	Түлш, халаалт	37,941,600.00	37,595,401.97	346,198.03	99.09
210303	Цэвэр, бохир ус	12,228,000.00	9,054,517.50	3,173,482.50	74.05
2104	Хангамж, бараа материалын зардал	56,622,300.00	42,036,601.00	14,585,699.00	74.24
210401	Бичиг хэрэг	8,269,800.00	8,255,010.00	14,790.00	99.82
210402	Тээвэр, шатахуун	970,000.00	970,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,620,500.00	3,073,491.00	2,547,009.00	54.68
210404	Ном, хэвлэл	21,400,000.00	21,100,000.00	300,000.00	98.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,355,600.00	840,000.00	6,515,600.00	11.42
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,006,400.00	7,798,100.00	5,208,300.00	59.96
2105	Нормативт зардал	4,846,800.00	2,801,420.00	2,045,380.00	57.80

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,471,800.00	1,426,420.00	2,045,380.00	41.09
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,375,000.00	1,375,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,070,500.00	39,383,000.00	2,687,500.00	93.61
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,950,800.00	16,870,800.00	80,000.00	99.53
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,988,000.00	2,380,500.00	2,607,500.00	47.72
210604	Урсгал засвар	20,131,700.00	20,131,700.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	39,999,500.00	37,089,500.00	2,910,000.00	92.72
210702	Дотоод албан томилолт	39,999,500.00	37,089,500.00	2,910,000.00	92.72
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,184,900.00	93,011,775.42	12,173,124.58	88.43
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,958,200.00	80,953,041.42	5,158.58	99.99
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,583,500.00	5,000,000.00	3,583,500.00	58.25
210803	Даатгалын үйлчилгээ	1,383,200.00	-	1,383,200.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	530,900.00	515,000.00	15,900.00	97.01
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	246,400.00	-	246,400.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	268,800.00	-	268,800.00	0.00
210807	Газрын төлбөр	13,213,900.00	6,543,734.00	6,670,166.00	49.52
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,868,000.00	3,839,200.00	28,800.00	99.26
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,868,000.00	3,839,200.00	28,800.00	99.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	178,010,200.00	177,932,060.33	78,139.67	99.96
2132	Бусад урсгал шилжүүлэг	178,010,200.00	177,932,060.33	78,139.67	99.96
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	21,000,000.00	21,000,000.00	-	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	157,010,200.00	156,932,060.33	78,139.67	99.95
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	158	145	13	91.77
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	127	120	13	94.49
620003	Үйлчлэх ажилтан	30	24	-	80.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	158	145	13	91.77
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	128	121	7	94.53
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	30	24	6	80.00

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	4	4	-	100.00
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	4	4	-	100.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	-	<b>2,134,362,084.02</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,134,362,084.02
122	Тусламжийн орлого	-	2,134,362,084.02
1221	Хандив тусламж /дотоод/	-	2,134,362,084.02
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,134,362,084.02
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	584,040,413.91
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,141,282,687.11
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	409,038,983.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>1,481,811,691.63</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,481,811,691.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,481,811,691.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	507,233,904.25
210105	Гэрээт ажлын хөлс	-	507,233,904.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	69,424,530.88
210201	Тэтгэврийн даатгал	-	69,424,530.88
2104	Хангамж, бараа материалын зардал	-	58,792,400.00
210401	Бичиг хэрэг	-	7,682,400.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,000,000.00
210404	Ном, хэвлэл	-	48,110,000.00
2105	Нормативт зардал	-	56,694,134.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	56,694,134.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	47,305,370.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	43,892,370.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	2,221,000.00
210604	Урсгал засвар	-	1,192,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	451,158,818.50
210701	Гадаад албан томилолт	-	104,777,596.50
210702	Дотоод албан томилолт	-	346,381,222.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	228,566,601.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	227,700,001.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	381,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	485,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	62,635,933.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	62,635,933.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	652,550,392.39
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	652,550,392.39
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	652,550,392.39

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

ШУА-ийн Газарзүй, Геоэкологийн Хүрээлэн нь Монгол орны газарзүй, хүрээлэн буй орчны чиглэлээр шинжлэх ухааны суурь болон хэрэглээний, технологи хөгжлийн судалгаа явуулах эрдэм шинжилгээний мэргэжлийн төрөлжсөн байгууллага юм.

Байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлыг судлан тэдгээр салбаруудад мэдлэгийн менежмент, инновацыг нэвтрүүлэх замаар Монгол улсын тогтвортой хөгжлийг хангахад хувь нэмэр оруулахад оршино.

ШУА-ын Газарзүй, Геоэкологийн Хүрээлэн нь Монгол орны физик газарзүй, нийгэм эдийн засгийн газарзүй, зурагзүй, геоморфологи, ландшафт, цэвдэг, ойн нөөц, ойн төлөв байдал, газрын нөөц, газар ашиглалт, усны нөөц, ус ашиглалт, хөрс, экологи, цөлжилтийн төлөв байдал, эдгээрийн хувьсал өөрчлөлтийн харилцан шүтэлцээг тодорхойлж, аж ахуйн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг урьдчилан судлан тогтоох, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, экосистемд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах шинжлэх ухааны үндэслэлийг орчин үеийн онолын судалгааны түвшинд боловсруулах, судалгаа, шинжилгээний үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх суурь ба хэрэглээний, технологи хөгжлийн судалгааг явуулах үндсэн үүрэгтэй.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

ШУА-ийн Газарзүй, Геоэкологийн Хүрээлэн нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн аудитын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Шинжлэх ухааны академийн эрхзүйн байдлын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Архивын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн албаны тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд хүрээлэнгийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- Сангийн сайдын 2025 оны А/03 тоот тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Газарзүй, геоэкологийн хүрээлэн нь дотоод аудиторын орон тоо байхгүй, 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд Эдийн засаг хөгжлийн яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт шалгалт хийгээгүй байна.

Тайлант онд тус хүрээлэнд Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газрын даргын баталсан удирдамжаар хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаа гэсэн 2 чиглэлээр дотоод хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус хүрээлэнгийн мөрдөж буй Монгол улсын Тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засаг хөгжлийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 26 өдрийн А/113 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь стандартад нийцсэн боловч үйл ажиллагааны онцлогт бүрэн тохирохгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2024 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 550,217.8 мянган төгрөгөөр буюу 17.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	315,154.9	652,550.4	337,395.5
Бараа материал	37,605.2	45,883.1	8,277.9
Үндсэн хөрөнгө	2,796,756.1	3,001,300.5	204,544.4
Нийт хөрөнгө	<b>3,149,516.2</b>	<b>3,699,734.0</b>	<b>550,217.8</b>
Нийт өр төлбөрийн дүн	-	2,000.0	2,000.0
цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,149,516.2	3,697,734.0	548,217.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<b>3,149,516.2</b>	<b>3,699,734.0</b>	<b>550,217.8</b>

Дээрх хүснэгтээс харахад: өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснуудад байна. Үүнд:

- Нэмэлт санхүүжилтийн гэрээт ажлууд болон төслийн санхүүжилтийг зарцуулах эрх нээгдээгүй тул үлдэгдэл санхүүжилтийг улсын төсөвт төвлөрүүлж, Сангийн яамны Төрийн сантай тооцоо нийлж, 652,550.4 мянган төгрөгийн авлага үүсгэсэн.
- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 8,277.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 256,117.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 247,839.6 мянган төгрөгийн бараа материалыг байгууллагын дотоод хэрэгцээнд зарцуулсантай холбоотой.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 204,544.4 мянган төгрөгөөр өссөн бөгөөд үүнд урсгал төсвийн санхүүжилтээр авсан 35,807.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 4,940.0 мянган төгрөгийн тавилга, 8,000.0 мянган төгрөгийн номын фонд болон Цөмийн энергийн төслөөс үнэ төлбөргүй орлогоор хүлээн авсан 412,256.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж зэргээс голлон нөлөөлсөн. Мөн ТӨБЗГ-ын 2025 оны 815 дугаар шийдвэрээр ашиглалтын хугацаа нь дууссан, үлдэх өртөггүй байсан 3 нэр төрлийн хөрөнгийг 31,800.0 мянган төгрөгөөр дахин үнэлж, орлогод авч тайлант хугацаанд 288,259.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна. Үүнээс биет бус хөрөнгийн үлдэгдэлд 10,467.0 мянган төгрөгийн программ хангамж, 556,096.1 мянган төгрөгийн 6 газар эзэмших эрх болон 164,700.0 мянган төгрөгийн 1 патентын эрх бүртгэлтэй байна.
- Засгийн газрын хувь оролцооны дансны үлдэгдэл нь 3,697,734.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 548,217.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус хүрээлэнгийн 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,244,647.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 799,868.8 мянган төгрөгөөр бууруулж, 5,444,778.4 мянган төгрөгөөр төсөв баталсан нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйтай холбоотой байна. Тайлант онд төсөвт тодотгол хийгдээгүй байна.

Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,444,778.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр урсгал төсвөөс 5,397,771.3 мянган төгрөгийн санхүүжилт авч 4,819,380.8 мянган төгрөгийг зарцуулж, 578,390.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,819,380.8 төгрөг буюу 88.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 625,397.6 мянган төгрөг, харуул хамгаалалтын зардлыг 5.2 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардлыг 78.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна. 2025 оны үр дүнгийн гэрээгээр 3 зорилт, 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн биелэлт нь 99 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71805	Шинжлэх ухаан, технологи нийт дүн	5,444,778.4	4,819,380.8	625,397.6	88.51
80101	Үндсэн үйл ажиллагаа	5,185,810.0	4,560,495.7	625,314.3	87.94
80210	Харуул хамгаалалт	77,029.3	77,024.1	5.2	99.99
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	178,010.2	177,932.1	78.1	99.96
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилээр гүйцэтгүүлэх	3,928.9	3,928.9	-	100.0

1. **Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар** : Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолоор орон тооны дээд хязгаарыг 158 орон тоогоор баталсан, 2025 онд нийт 120-130 ажилтан үндсэн цалингаа авч, ажилласан, 12 ажилтан гадаадад суралцах чөлөөтэй, 10 ажилтан хүүхэд асрах чөлөөтэй байгаа боловч сул чөлөөтэй орон тоон дээр 9 ажилтныг шинээр нэмж ажиллуулж байна. Мөн Улсын их хурлын 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл"-д "Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ" гэж заасны хэрэгжүүлээгүй, байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог 9.0 хувиар бууруулах арга хэмжээг авч ажиллаагүй байна.
2. **Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар**: Монгол улсын засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.4, хүрээлэнгийн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/13 тоот тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын 12.3-т заасан заалтыг үндэслэн нэг хүнд ногдох унааны зардлыг 2.0 мянган төгрөг, хоолны зардлыг 15.5 мянган төгрөг байхаар тус тус заасан байна.
3. **Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны үр дүн**: Тайлант онд тус хүрээлэн гадаад томилолтод нийт 104,777.6 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээс зарцуулсан бөгөөд үр дүнг товч нэгтгэв:
  - ОХУ (Халиа, 03.28-04.03): 5,240.0 мянган төгрөгөөр халианы 10 цэгээс дээж авч химийн өгөгдөл бүрдүүлэн, тархалтыг дроноор баримтжуулсан;
  - Япон улс (Замын хөлдөлт, 05.25-05.31): 1,458.6 мянган төгрөгөөр төслийн үр дүнг хэлэлцэж, судалгааны иж бүрдэл багаж, дроныг лабораторид суурилуулсан;
  - ОХУ (УЦС-ын экспертиз, 05.11-05.25): 45,618.2 мянган төгрөгөөр Эгийн голын УЦС-ын нөлөөллийг Орос-Монголын шинжээчид хэлэлцсэн;
  - ОХУ (УЦС-ын судалгаа, 09.07-10.09): 31,165.1 мянган төгрөгөөр (багц зардал) 156 хоногийн хээрийн судалгаа гүйцэтгэж, 200 орчим дээжид шинжилгээ хийсэн;
  - БНХАУ (Нуур судлал, 10.16-10.27): 12,647.4 мянган төгрөгөөр хамтарсан өгүүлэл хэвлүүлж, "Цэнхэр ном" болон ажиглалтын суурин байгуулах суурийг тавьсан;
  - БНХАУ & ОХУ (Санамж бичиг, 10.30-12.17): 8,648.4 мянган төгрөгөөр (багц зардал) ШУА-ийн хамтын ажиллагааг шинэчилж, хамтарсан монографийг хэвлэлтэд бэлэн болгосон байна.
4. **Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүн**:
  - Олон улсын эрдэм шинжилгээний хурал: "Хүрээлэн буй орчин ба технологи" сэдэвт 5 дахь удаагийн хурлыг Улаанбаатар хотноо зохион байгуулж, 10 гаруй орны 220 гаруй төлөөлөгч оролцон судалгааны шинэ арга зүй, технологийн ололт амжилтаа хуваалцсан байна. Хурлын бүтээлүүдийг "Монгол орны газарзүй, геоэкологи" сэтгүүлийн англи хэл дээрх тусгай дугаарт хэвлэн олны хүртээл болгожээ.
  - Орон нутгийн чадавхжуулах сургалт: Хамтарсан төслүүдийн хүрээнд малчид, иргэд болон бодлого боловсруулагчдад зориулсан уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн үнэлгээ, дасан зохицох бодлогын хэлэлцүүлэг, сургалтуудыг орон нутагт амжилттай зохион байгуулсан байна.
5. **Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээний талаар**: Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээнд 24,610.0 мянган төгрөг зарцуулсан бөгөөд гэрээний үр дүнг нэгтгэв:
  - "Гоо дизайн" ХХК: 11,000.0 мянган төгрөгийн гэрээгээр "Хөрсний хүнд металлыг бууруулах Phytoremediation технологи" гарын авлага 500 ширхэг, сурталчилгааны хатуу постер 100 ширхгийг тус тус хэвлүүлсэн;
  - "Удам соёл" ХХК: 8,610.0 мянган төгрөгийн гэрээгээр "Монгол улс, ОХУ Сибирийн бүс нутаг: хүн ам, эдийн засаг, байгаль ашиглалт" сэдэвт 300 ширхэг гарын авлага хэвлүүлсэн;

- “Соёмбо принтинг” ХХК: 5,000.0 мянган төгрөгийн гэрээгээр “Статистикийн R программ ашиглан өгөгдлийн дүн шинжилгээ хийх аргачлал” гарын авлага 100 ширхгийг хэвлүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаас 584,040.4 мянган төгрөг, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 1,141,282.7 мянган төгрөг, нийт 2,134,362.1 мянган төгрөгийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 507,233.9 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 69,424.5 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 58,792.5 мянган төгрөг, норматив зардалд 56,694.1 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 47,305.4 мянган төгрөг, албан томилолтонд 451,158.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжинд 228,566.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 62,635.9 мянган төгрөг, нийт 1,481,811.7 мянган төгрөгийг зарцуулж, 652,550.4 мянган төгрөгийг улсын орлогод төвлөрүүлж татаас санхүүжилтийн авлагаар тооцоо нийлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### 3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус хүрээлэн тайлант онд 3 чиглэлийн хүрээнд нийт 58 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 8,013,423.4 мянган төгрөгийг зарцуулж, хэрэгжүүлсэн байна. Үйл ажиллагааны хүрэх үр дүн, биелэлтийг Хүснэгт 3-т үзүүлэв. Үүнд:

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

<i>/мянган төгрөгөөр/</i>						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	“Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого хэрэгжүүлэх 26 үйл ажиллагаа, арга хэмжээ	2025-01-12 сар	26 үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөсөн.	26 үйл ажиллагааны 100 гүйцэтгэл хувь биелсэн.	406,039.0	406,039.0
1.1	“Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогод ШУА-ийн оролцоог нэмэгдүүлэх” 5 арга хэмжээ	2025-01-12 сар	5 арга хэмжээг төлөвлөсөн.	5 үйл ажиллагааны гүйцэтгэл 99 хувь биелсэн.	134,548.5	134,548.5
1.2	“ШУА-ийн менежментийн чадавхыг бэхжүүлэх”	2025-01-12 сар	9 үйл ажиллагаа,	9 үйл ажиллагааны	72,399.3	72,399.3

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	зорилтыг хангах зорилтын хүрээнд 9 арга хэмжээг зохион байгуулна.		арга хэмжээг төлөвлөсөн.	гүйцэтгэл 100 хувь биелсэн.		
1.3	“Судалгаа хөгжүүлэлтийн ажлын чанар, өгөөжийг дээшлүүлэх” зорилтыг хангах 12 арга хэмжээг хэрэгжүүлнэ	2025-01-12 сар	12 үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөсөн.	12 үйл ажиллагааны гүйцэтгэл 96.6 хувь биелсэн.	199,091.2	199,091.2
2	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ	2025-01-12 сар	6 үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөсөн.	6 үйл ажиллагааны гүйцэтгэл 100 хувь биелсэн.	6,063,413.9	5,483,967.3
2.1	“Судалгаа хөгжүүлэлтийн ажлын орчин нөхцөлийг сайжруулах” зорилтыг хангах 4 арга хэмжээ	2025-01-12 сар	4 үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөсөн.	4 үйл ажиллагааны гүйцэтгэл 100 хувь биелсэн.	4,922,131.2	4,342,684.6
2.2	“Инновацын орчин, соёлыг төлөвшүүлж, нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх” зорилтыг хангах зорилтыг хангах 2 арга хэмжээ	2025-01-12 сар	2 үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөсөн.	2 үйл ажиллагааны гүйцэтгэл 100 хувь биелсэн.	1,141,282.7	1,141,282.7
3	ХУУЛИАР ОЛГОСОН ТУСГАЙЛАН БОЛОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ	2025-01-12 сар	12 үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөсөн.	12 үйл ажиллагааны гүйцэтгэл 100 хувь биелсэн.	2,165,439.2	2,123,417.1
3.1	“УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газарт улс орны нийгэм, эдийн засгийн асуудлаар санал, зөвлөмж боловсруулж, хүргүүлэх” зорилтыг хангах 3 арга хэмжээ 3	2025-01-12 сар	3 үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөсөн.	3 үйл ажиллагааны гүйцэтгэл 100 хувь биелсэн.	518,718.3	476,696.2
3.2	“Салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, менежментийг сайжруулах” зорилтыг хангах 4 арга хэмжээ	2025-01-12 сар	5 үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөсөн.	5 үйл ажиллагааны гүйцэтгэл 100 хувь биелсэн.	242,680.5	242,680.5
3.4	“Эрдэм шинжилгээний байгууллага, их сургууль, төр болон орон нутаг, бизнесийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх” зорилтыг хангах 2 арга хэмжээ	2025-01-12 сар	2 үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөсөн.	2 үйл ажиллагааны гүйцэтгэл 100 хувь биелсэн.	384,040.4	384,040.4

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3.5	“Гадаад харилцаа, хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх” зорилтыг хангах 15 арга хэмжээ	2025-01-12 сар	16 үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөсөн.	16 үйл ажиллагааны гүйцэтгэл 98.1 хувь биелсэн.	584,040.4	584,040.4
3.6	“Манлайлал, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх” зорилтыг хангах 2 арга хэмжээ	2025-01-12 сар	2 үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөсөн.	2 үйл ажиллагааны гүйцэтгэл 100 хувь биелсэн.	420,000.0	420,000.0

#### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн гадаад төслийн эх үүсвэрээр хээрийн судалгааны төвийн засвар үйлчилгээний ажил хийхэд 40,000.0 мянган төгрөг, хээрийн судалгааны ТЭЗҮ бэлтгэхэд 45,000.0 мянган төгрөг, нийт 85,000.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан төрийн худалдан авах ажиллагааны цахим сайтад байршуулсан боловч гүйцэтгэл гараагүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төгсгүүд консалтинг аудит ХХК-ийн аудитор А.Саранцэцэг, аудиторын туслах Ч. Мандахтуяа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Сарантуяа, компанийн захирал, аудитор Р. Даваа нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Тэлмүүн, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц. Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 1/12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг аудит хийсэн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 6,045,603.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 60,456.0 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага тэвчиж болох зардлуудыг гаргахгүй байх, зайлшгүй шаардлагатай зардлуудыг эрэмбэлэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд хязгаарласан 32 заалтуудыг хамруулан горим сорил хэрэгжүүлсэн, аудитаар зөрчил илрээгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 847,377.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд нийт 171 мэдээлэл байршуулахаас 169 мэдээлэл байршуулж, 2 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй байна.

**Илрүүлэлт:** Шилэн дансны цахим системд 847,377.2 мянган төгрөгийн 7 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1.2-т "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны цахим системд мэдээллийг хугацаанд нь ил тод, үнэн зөв, иж бүрэн байршуулж байх зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитад хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага, өглөг, үндсэн хөрөнгийн данснуудад горим сорил хэрэгжүүлсэн. Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулан завсрын аудитаар илрүүлсэн 559,620.1 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 113.654.6 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг өгснийг хэрэгжүүлж, биелэлт 100 хувьтай байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	113,654.6	2	113,654.6	100
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>113,654.6</b>	<b>2</b>	<b>113,654.6</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг сайжруулахтай холбоотой дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

1. Журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт болон Сангийн яамны [finperform.mof.gov.mn](http://finperform.mof.gov.mn) сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах.
2. Журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан дансны жишиг жагсаалтыг дээрх Сангийн яамны шинэ сайттай уялдуулах.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 706,096.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад бүрэн залрууллаа.

*Залруулсан алдаа:*

- Бараа материалын шинжтэй 5,405.5 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн;
- Балансын "Авлага" дансны ДТ болон "Өглөг" дансны КТ-д 700,691.1 мянган төгрөгийн ажил гүйлгээг ижил дүнгээр тохируулах бичилт хийж, тайлагнасан;

Энэ нь УСНББОУС 3-Нягтлан бодох бүртгэлийн бодлого, тооцооллын өөрчлөлт ба алдаа стандартын 46-т "... тайлант үед илрүүлсэн уг тайлант үеийн боломжит алдааг тухайн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөхөөс өмнө засварладаг...", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2-т "нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", санхүүгийн тайлагналийн толилуулгын батламж мэдэгдлийг хангахгүй тул залруулсан.

Аудитаар нийт 1,273.2 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд, 1 албан шаардлага хүргүүлж, 1,273.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 1,273.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 59,182.8 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

*Илрүүлэлт 1:* Тус хүрээлэнгийн бүтэц орон тоог Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн хурлын 2025 оны 04 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд 2025 онд албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй мөн 2025 оны 8 дугаар сарын 01-нээс сул орон тоон дээр 9 хүн шинээр нөхөж ажилд томилсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.6-т "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.", Ерөнхий сайдын 2025 оны 7 сарын 25-ны өдрийн 04 тоот албан даалгаврын 1.2-т "төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байх..." гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Ерөнхий сайдын 2025 оны 7 дугаар сарын 04 тоот албан даалгаварыг хэрэгжүүлж байгууллагын бүтэц орон тоог 9 хувиар бууруулаагүй, сул орон тоон дээр нөхөн

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

томилгоо хийсэн зөрчлийг таслан зогсоож, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

## 5.2 Зөвлөмж

Илрүүлэлт 1: Нийгмийн даатгалын тайланг 792.0 мянган төгрөг, Хувь хүний орлогын албан татварын тайланг 481.2 мянган төгрөг, нийт 1,273.2 мянган төгрөгөөр алдаатай тайлагнасан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19.1-д "Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна"; 19.1.1-д "Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, олговор"; 19.1.4-д "үндсэн ажлаас бусад хуулийн этгээд, хүнээс олгосон энэ хуулийн 19.1.1-д заасан цалин хөлс, олговор"; 19.1.5-д "Төрийн албаны тухай хуулийн 57.2-т заасан цалин хөлс" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алба хаагчдын цалин хөлсийн бүртгэлийг үнэн зөв бүртгэж, нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татварыг хуулийн дагуу зөв суутган авч, тайлагнаж байх

Дээрх шийдвэрийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Балансын "Авлага" дансны ДТ болон "Өглөг" дансны КТ-д 700,691.1 мянган төгрөгийн ажил гүйлгээг ижил дүнгээр тохируулах бичилт хийж, тайлагнасан.	1	700,691.1			1	700,691.1	1	700,691.1				
Бараа материалын шинжтэй 5,405.5 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна.	1	5,405.5			1	5,405.5	1	5,405.5				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>706,096.6</b>			<b>2</b>	<b>706,096.6</b>	<b>2</b>	<b>706,096.6</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Нийгмийн даатгалын тайланг 792.0 мянган төгрөг, Хувь хүний орлогын албан татварын тайланг 481.2 мянган төгрөг, нийт 1,273.2 мянган төгрөгөөр алдаатай тайлагнасан.	1	1,273.2						1	1,273.2
Тус хүрээлэнгийн бүтэц орон тоог Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн хурлын 2025 оны 04 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд 2025 онд албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй мөн 2025 оны 8 дугаар сарын 01-нээс сул орон тоон дээр 9 хүн шинээр нөхөж ажилд томилсон.	1	-			1			-	
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1,273.2</b>			<b>1</b>			<b>1</b>	<b>1,273.2</b>

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>						
Шилэн дансны цахим системд 847,377.2 мянган төгрөгийн 7 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.	1	847,377.2			1	847,377.2
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>847,377.2</b>			<b>1</b>	<b>847,377.2</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 360/А0150061

Улаанбаатар хот

САГ-2026/65/НА -СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Газарзүй геоэкологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус хүрээлэнгийн бүтэц орон тоог Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн хурлын 2025 оны 04 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд 2025 онд албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй, мөн 2025 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс сул орон тоон дээр 9 хүн шинээр нөхөж ажилд томилсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.", Ерөнхий сайдын 2025 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 04 тоот албан даалгаврын 1.2-т "төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байх..." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ерөнхий сайдын 2025 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 04 тоот албан даалгаврыг хэрэгжүүлж байгууллагын бүтэц орон тоог 9 хувиар бууруулаагүй, сул орон тоон дээр нөхөн томилгоо хийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Газарзүй, гео-экологийн хүрээлэнгийн захирал А.Дашцэрэн, нягтлан бодогч Б.Лхагвасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ТӨГСГҮҮД КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ

Р.ДАВАА